

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202110703

1. “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” төслийн нэгж нь Газрын доорх байгууламжуудын зураг төсөл, төсөв, интерьер, дизайны зураг төсөл, төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Газрын доорх байгууламжуудын зураг төсөл, төсөв, интерьер, дизайны зураг төсөл, төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ ба тус ажлыг хийж гүйцэтгэснээр аялал жуулчлал хөгжих нэг шат болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
 - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар авч/ ирүүлнэ.
 - Тусгай зөвшөөрөл
 - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
 - Сүүлийн 2 жилийн аль нэг жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2021 оны 10 дугаар сарын 22–ны өдрийн 09 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2021 оны 10 дугаар сарын 26–ны өдрийн 09 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг: tender.gov.mn